



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн  
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 26  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА Б.МАЙДАРМАА  
ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>47,121,373.13</u></b>	<b><u>81,810,873.98</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	47,121,373.13	81,810,873.98
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	0.00	25,203,072.00
35110	Тусгай зориулалттай материал	-	25 203 072.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	26,851,373.13	34,307,801.98
35410	Бичиг хэргийн материал	6,614,385.52	7,729,092.50
35420	Аж ахуйн материал	16,296,650.36	20,223,640.36
35430	Сэлбэг хэрэгсэл	155,300.00	155,300.00
35470	Бусад хангамжийн материал	3,785,040.25	6,199,769.10
35600	Мал амьтад	20,270,000.00	22,300,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,558,646,329.77</u></b>	<b><u>4,054,143,972.95</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,558,646,329.77	4,054,143,972.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,345,109,915.77	3,840,690,058.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,059,934,296.50	2,059,934,296.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-172,308,638.36	-252,443,361.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	171,786,600.00	154,737,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-140,123,472.33	-127,789,309.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	361,909,264.70	2,021,138,931.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-124,857,417.17	-176,171,305.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	230,985,473.00	231,292,361.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,216,190.57	-70,008,652.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	122,000.00	122,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-122,000.00	-122,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	129,256,180.00	129,256,180.00
39303	Бусад биет бус хөрөнгө	213,309,539.00	213,309,539.00
39301	Программ хангамж	5,550,000.00	5,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,323,125.00	-5,405,625.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,605,767,702.90</u></b>	<b><u>4,135,954,846.93</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,605,767,702.90</u></b>	<b><u>4,135,954,846.93</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,048,408,938.37	1,048,408,938.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,048,408,938.37	1,048,408,938.37
51101	Өмч: - төрийн		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	794,500,096.01	2,324,687,240.04
51210	Өмнөх үеийн үр дүн	794,500,096.01	794,500,096.01

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1036511761,53</b>	<b>2508859702,00</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>308871161,53</b>	<b>1697654302,00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	308871161,53	1697654302,00
120005	Түрээсийн орлого	10291200,00	4768455,00
120009	Бусад орлого	298579961,53	1692885847,00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>727640600,00</b>	<b>811205400,00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	727640600,00	811205400,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	727640600,00	811205400,00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>831977235,78</b>	<b>978649677,97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>831977235,78</b>	<b>978649677,97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>776901876,58</b>	<b>901325785,59</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407075487,44	453161674,26
210101	Үндсэн цалин	352495487,44	375089299,24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11580000,00	26603500,02
210104	Урамшуулал	43000000,00	51468875,00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53629014,21</b>	<b>77576000,00</b>
210201	Тэтгэврийн даатгал	37138223,48	58983610,47
210202	Тэтгэмжийн даатгал	4122697,80	4648097,47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4122697,69	4648097,50
210205	Эрүүл мэндийн даатгал	8245395,24	9296194,56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46458302,95</b>	<b>43679281,69</b>
210301	Гэрэл, цахилгаан	5739450,00	5803582,69
210302	Түлш, халаалт	34693216,00	28009038,00
210303	Цэвэр, бохир ус	6025636,95	9866661,00
2104	Хангамж, бараа материалын зардал	19702348,21	19746498,67
210401	Бичиг хэрэг	3150600,00	3087900,00
210402	Тээвэр, шатахуун	11295100,00	10000000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1253119,21	1188698,67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398900,00	398900,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3604629,00	4900000,00
210408	Бараа материал акталсны зардал		171000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53266796,00	52394213,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	360200,00	1336829,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5303600,00	20329050,00
210604	Урсгал засвар	47602996,00	30728334,00
2107	Томилолт, зочны зардал	2034900,00	2000000,00
210702	Дотоод албан томилолт	2034900,00	2000000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58060987,15	64649206,15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51567764,40	58300000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864000,00	864000,00
210803	Даатгалын үйлчилгээ	900000,00	900000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112800,00	112800,00

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100000,00	109845,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203399,00	405500,00
210807	Газрын төлбөр	1161930,00	1237530,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3151093,75	2719531,15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136674040,62	188118911,82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11190000,00	17480000,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124335439,62	170638911,82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55075359,20</b>	<b>77323892,38</b>
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3950880,00	1554488,00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3950880,00	1554488,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	51124479,20	75769404,38
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51124479,20	75769404,38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	204534525,75	1530210024,03
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0,00	22880,00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		22880,00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>0,00</b>	<b>-22880,00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>204534525,75</b>	<b>1530187144,03</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,048,408,938.37	762,858,668.52	589,965,570.26	2,401,233,177.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	1,048,408,938.37	762,858,668.52	589,965,570.26	2,401,233,177.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			204,534,525.75	204,534,525.75
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,048,408,938.37</b>	<b>762,858,668.52</b>	<b>794,500,096.01</b>	<b>2,605,767,702.90</b>
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,048,408,938.37</b>	<b>762,858,668.52</b>	<b>794,500,096.01</b>	<b>2,605,767,702.90</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,048,408,938.37</b>	<b>762,858,668.52</b>	<b>794,500,096.01</b>	<b>2,605,767,702.90</b>

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			1,530,187,144.03	1,530,187,144.03
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,048,408,938.37</b>	<b>762,858,668.52</b>	<b>2,324,687,240.04</b>	<b>4,135,954,846.93</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>738,351,800.00</b>	<b>815,973,855.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,711,200.00</b>	<b>4,768,455.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,711,200.00</b>	<b>4,768,455.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>420,000.00</b>	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	420,000.00	-
120005	Түрээсийн орлого	10,291,200.00	4,768,455.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>727,640,600.00</b>	<b>811,205,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	727,640,600.00	811,205,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	727,640,600.00	811,205,400.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>704,484,816.00</b>	<b>789,245,675.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>460,093,248.66</b>	<b>530,737,674.26</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>649,409,456.80</b>	<b>711,921,782.62</b>
21	<b>ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ</b>	<b>460,093,248.66</b>	<b>530,737,674.26</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>402,605,348.66</b>	<b>453,161,674.26</b>
210101	Үндсэн цалин	251,411,002.73	278,666,327.60
210102	Нэмэгдэл	91,914,594.96	89,044,448.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,675,000.00	32,819,720.00
210104	Урамшуулал	46,604,750.97	52,631,178.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,487,900.00</b>	<b>77,576,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,100,300.00	60,053,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,346,900.00	2,604,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,677,500.00	7,103,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	669,400.00	710,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,693,800.00	7,103,800.00
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>738,351,800.00</b>	<b>815,973,855.00</b>
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,458,303.53</b>	<b>43,679,281.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,739,450.00	5,803,582.69
210302	Түлш, халаалт	34,693,216.00	30,960,651.00
210303	Цэвэр, бохир ус	6,025,637.53	6,915,048.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,620,419.21</b>	<b>19,779,498.67</b>

**Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210401	Бичиг хэрэг	3,191,900.00	3,191,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,295,100.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,187,719.21	1,188,698.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398,900.00	398,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,546,800.00	5,000,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>57,605,276.00</b>	<b>50,505,153.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,316,000.00	1,766,819.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5,420,600.00	14,605,000.00
210604	Урсгал засвар	50,868,676.00	34,133,334.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,034,900.00</b>	<b>2,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,034,900.00	2,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>62,107,009.40</b>	<b>65,220,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,656,879.40	58,300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,800.00	112,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	109,845.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	626,400.00	696,000.00
210807	Газрын төлбөр	1,161,930.00	1,237,530.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,685,000.00	3,000,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,490,300.00</b>	<b>-</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,490,300.00	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,075,359.20</b>	<b>77,323,892.38</b>
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,950,880.00</b>	<b>1,554,488.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,950,880.00	1,554,488.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,124,479.20</b>	<b>75,769,404.38</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,124,479.20	75,769,404.38
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>33,866,984.00</b>	<b>26,728,180.00</b>
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>-</b>	<b>-</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>33,866,984.00</b>	<b>26,728,180.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,866,984.00</b>	<b>26,728,180.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>33,866,984.00</b>	<b>26,728,180.00</b>
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,866,984.00	26,728,180.00
2260	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>-</b>
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-33,866,984.00</b>	<b>-26,728,180.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>

300001	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	500,000.00	0.00
	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>818,205,400.00</b>	<b>814,233,137.00</b>
	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>818,205,400.00</b>	<b>814,233,137.00</b>
	<b>Татварын бус орлого</b>	<b>818,205,400.00</b>	<b>814,233,137.00</b>
	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>7,000,000.00</b>	<b>3,027,737.00</b>
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	7,000,000.00	3,027,737.00
	<b>Тусламжийн орлого</b>	<b>811,205,400.00</b>	<b>811,205,400.00</b>
122005	Төсвөөс санхүүжих	811,205,400.00	811,205,400.00
	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>818,205,400.00</b>	<b>738,916,628.62</b>
	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>818,205,400.00</b>	<b>738,916,628.62</b>
	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>818,205,400.00</b>	<b>738,916,628.62</b>
	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>818,205,400.00</b>	<b>738,916,628.62</b>
	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>482,887,600.00</b>	<b>453,161,674.26</b>
210101	Үндсэн цалин	308,392,400.00	279,371,985.60
210102	Нэмэгдэл	89,834,400.00	89,411,048.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,960,800.00	32,819,720.00
210104	Урамшуулал	51,700,000.00	51,558,920.00
	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,049,500.00</b>	<b>77,576,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,290,000.00	60,290,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,841,500.00	2,368,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,103,800.00	7,103,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	710,400.00	710,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,103,800.00	7,103,800.00
	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,349,000.00</b>	<b>43,679,281.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,974,000.00	5,803,582.69
210302	Түлш, халаалт	55,816,600.00	30,960,651.00
210303	Цэвэр, бохир ус	20,558,400.00	6,915,048.00
	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,779,500.00</b>	<b>19,779,498.67</b>
210401	Бичиг хэрэг	3,191,900.00	3,191,900.00
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,188,700.00	1,188,698.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	398,900.00	398,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,000,000.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	77,500,000.00	77,499,999.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,800,000.00	19,799,999.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,700,000.00	16,700,000.00
210604	Урсгал засвар	41,000,000.00	41,000,000.00
	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00
	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>65,639,800.00</b>	<b>65,220,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,300,000.00	58,300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,800.00	112,800.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145,000.00	109,845.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	696,000.00	696,000.00
210807	Газрын төлбөр	1,622,000.00	1,237,530.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,000,000.00	3,000,000.00
261090	261090	0.00	75,769,404.38
299990	299990	500,000.00	0.00
300011	300011	0.00	186,230.00
300015	300015	0.00	266,666.00
	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>0.00</b>	<b>75,316,508.38</b>
	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>-75,316,508.38</b>
	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>0.00</b>	<b>-75,316,508.38</b>
	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>500,000.00</b>	<b>75,316,508.38</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	29.00	27.00
620001	Удирдах ажилтан	2.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	12.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж,

2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Гаалийн байгууллага нь гадаад харилцаа, хамтын ажиллагааг гаалийн бодлого, тэргүүлэх чиглэл, стратегитай уялдуулан хөгжүүлж, өргөжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. ДГБ, олон улсын бусад байгууллага, гадаад орны гаалийн байгууллагуудтай гаалийн асуудлаар хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан үр ашигтай байх нөхцлийг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажилладаг байна.

Орхон аймгийн Гаалийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 752,905.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,529.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,270.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,530,187.1 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Бараа материал	47,121.3	81,810.8	34,689.5
Үндсэн хөрөнгө	2,558,646.3	4,054,143.9	1,495,497.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,605,767.7</b>	<b>4,135,954.8</b>	<b>1,530,187.1</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,048,408.9	1,048,408.9	-
Хуримтлагдсан үр дүн	794,500.0	2,324,687.2	1,530,187.1
Өмнөх үеийн үр дүн	794,500.0	794,500.0	-
Тайлант үеийн үр дүн	-	1,530,187.1	1,530,187.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	762,858.6	762,858.6	
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,605,767.7</b>	<b>4,135,954.8</b>	<b>1,530,187.1</b>

Бараа материалын данс нь өмнөх оноос 81,810.8 мянган төгрөг болж 34,689.5 мянган төгрөгөөр өссөн нь Гаалийн салбар лабораторийн үйл ажиллагаа шинээр эхэлж хөдөлмөр хамгааллын болон тусгай зориулалтын материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,054,143.9 мянган төгрөг болж 1,495,497.6 мянган төгрөгөөр өссөн нь Гаалийн Ерөнхий газраас Орхон аймаг дахь Гаалийн салбар лабораторийг ажиллуулж эхлэхтэй холбогдуулан тоног төхөөрөмжийг шилжүүлэн суурилуулсан. Газрын даргын тушаалаар багаж хэрэгслийн зардлаар Гаалийн салбар лабораторид шатаах зуух, ус нэрэгчийн аппарат, баримт ариутгагч, баримт үдэгч машин, зэргийг багаж хэрэгслийн зардлаар авсан. ТӨБЗГ-ын 2021 оны тогтоолоор 23,649.5 мянган төгрөгийн автомашин акталсан нь нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймаг дахь Гаалийн газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,156,534.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,156,534.0 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 133,183.1 мянган төгрөгөөр бууруулан 811,205.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийсэн байна. Салбар лабораторийн албан хаагчид нэмэгдэж Цалингийн зардлыг өсгөж тодотгол хийсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, гаалийн хилээр бараа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 811,205.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 3,027.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 738,916.6 мянган төгрөгийг зарцуулж, 75,769.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 738,916.6 мянган төгрөг буюу 91.0 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 29,726.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 473.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 45,570.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтын дансаар хөрөнгө аваагүй болно.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймаг дахь Гаалийн газар нь 2021 онд нийт 738,916.6 мянган төгрөгийн 150 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 150 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Мөн тус байгууллага нь санхүү төсөв хөрөнгөтэй холбоотой бүх хэлбэрийн үйл ажиллагаа, сургалт, мэдээ тайлан төлөвлөгөө, төсвийн жилийн хуваарийг тодотгол өөрчлөлт хийх бүрд шинэчлэн харилцаанд оролцогчид, ажилтан, ажиллагсдад ил тод харагдахуйцаар байгууллагын самбарт байршуулж хэвшсэн.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитаас итгэл үзүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 998.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 640.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 357.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Гэрээт албан хаагчийн ХХОАТ-ыг суутган авсан хэдий ч Татварын тайланд тайлагнаагүй орхисон байсан 640.8 мянган төгрөгийг тайлант хугацаанд багтаан залруулж тайлагнуулав.

### **4.3 Албан шаардлага**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Тус байгууллагын 2021 оны 08 сарын НДШ-ийн тайланд 1 албан хаагчийн цалинг давхар тооцож 357.3 мянган төгрөгийн НДШ илүү тооцсон нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17.1.1-д “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Хөдөлмөрийн хөлсний орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлж, хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гаалийн газар	2	998.1	1	640.8					1	357.3
<b>Нийт дүн</b>		2	998.1	1	640.8					1	357.3

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Ц.НАРМАНДАХ